

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирлын тойм мэдээ

МАНАЙ ҮНДСЭН ЗОРИЛГО

Дэлхийд тэргүүлэх, аюулгүй, тогтвортой зэсийн бизнесийг хамтдаа цогцлоож, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах

МАНАЙ АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ

МАНАЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

ХАМТ ОЛОН




ШИЛДЭГ АЖИЛ
ОЛГОГЧ БАЙНА

ХАМТЫН
АЖИЛЛАГАА



ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН
ТҮНШ БАЙНА

ХӨРСТ ДЭЛХИЙ



ЭХ ДЭЛХИЙГЭЭ
ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

ХҮРТЭХ ӨГӨӨЖ



ТОГТВОРТОЙ
ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

- Эрүүл, аюулгүй, хүн бүрийн оролцоо, олон талт байдлыг дэмжсэн ажлын орчин бүрдүүлж, соёлыг төлөвшүүлнэ.
- Үе үеийн төлөөлөл мөр зэрэгцэн урам зоригтой ажиллах боломж бүрдүүлж, чадварлаг ажилтнуудыг эгнээндээ элсүүлж, тогтвортой ажиллах урам зоригоор тэтгэнэ.
- Дэлхийн түвшинд үнэлэгдэхүйц өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ.

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн үйлсийг компани даяараа онцгойлон чухалчилж, биелүүлэх арга замыг эрэлхийлнэ.
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалж, сайжруулна.
- Компанийн үйл ажиллагаанаас газар, ус, агаарын чанарт учирч болох сөрөг нөлөөллөөс сэргийлж, бууруулна.
- Улс орны хэмжээнд усны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтарч ажиллана.
- Уурхайн хаалтын дараах нөлөөллийг багасгахад чиглэсэн бизнесийн үйл ажиллагааг явуулна.



ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлж төлөвшүүлнэ.
- Харилцан ашигтай зорилгын төлөө оролцогч талуудтайгаа нэгдэнэ.
- Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хурдасгах зорилгоор бизнесийн түншүүдтэйгээ хамтарч ажиллана.
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр түншилж ажиллана.

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

- Урт хугацаанд үр ашгаа хүртээх, дэлхийд тэргүүлэх зэсийн үйлдвэрлэлийг цогцлооно.
- Стратегиа оновчтой төлөвлөж, хүдрийн биетийн судалгаанд хөрөнгө оруулах замаар үр ашгийг боломжит дээд түвшинд хүргэж нэмэгдүүлнэ.
- Нэгдмэл, уян хатан, шинийг санаачилдаг, шинэ техник, технологи ашигладаг, тасралтгүй суралцдаг тэргүүний компани байна.
- Ханган нийлүүлэлтийн сүлжээ, түүний дотор цахилгаан эрчим хүчний чадамж, тогтвортой байдлыг сайжруулж, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнийг илүү олон харилцагчдад нийлүүлнэ.



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Шилдэг ажил
олгогч байна

Хамт олон




Хамтын
ажиллагаа



Хөрст дэлхий



Хүртэх өгөөж



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ МЭНД

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд зогсоох эрхтэй.

2025 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР

27,040,848 ХҮН/ЦАГ

2025 оны гуравдугаар улиралд гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.16 ноогдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг хамгийн сайн хангадаг уурхайн нэг болж байна.



ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

***0.23-ААС БАГА БАЙЛГАХ**

ГҮЙЦЭТГЭЛ **0.16**



БОЛОВСРОЛ СУРГАЛТ (НИЙТ ХҮН/ЦАГ)

2025 оны гуравдугаар улиралд **226,323** хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь дээшлүүлсээр байна.



БОЛОВСРОЛ, ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

УЛСЫН ХЭМЖЭЭНД

2010 оноос хойш **2,219** сурагч/оюутан Залуусын хөгжлийн хөтөлбөр, Дотоодын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдлаа.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД

2016 оноос хойш **815** оюутан Говийн оюу оюутны тэтгэлэг, Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хамрагдлаа.



КАРЬЕР ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

2013 оноос хойш **1,617** сурагч/оюутан Шинэ төгсөгчийн хөтөлбөр, Дадлагын болон Дадлагажигч хөтөлбөр, Ажил, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдлаа.



ХАМТ ОЛОН

97.5%

ҮҮРЭГ 90%



ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

24.1%

ЗОРИЛТ 25%

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа




Хөрст дэлхий



Хүртэх өгөөж

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(2025, III УЛИРАЛ)



Боловсрол	₮213 сая
Байгаль орчин	₮2.9 тэрбум
Түүх соёл	₮158 сая
Эрүүл мэнд, сайн сайхан байдал	₮629 сая
Дэд бүтэц	₮4 тэрбум
Спорт	₮834 сая

Тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 2015 оноос хойш 2025 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 233.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2025, III УЛИРАЛ)

587
ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ

ТАТВАР ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ ТӨЛЖЭЭ.

Татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ* зэрэг бусад төлбөрт **13.7 их наяд** төгрөг** 2010 оноос хойш төлсөн.

* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

** Энэ дүнд олон улсын арбитрт хэлэлцэгдэж буй 1.3 их наяд төгрөгийн татварын маргааны төлбөр багтсан болно.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2025, III УЛИРАЛ)



ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

(2025, III УЛИРАЛ)

1.41
ИХ НАЯД ТӨГРӨГ

2025 оны гуравдугаар улиралд үйл ажиллагааны худалдан авалтын баг 736 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 553 нь дотоодын ханган нийлүүлэгчид байв. Эдгээр дотоодын компанид худалдан авалтынхаа 90 хувийг зарцуулав. 2010 оноос хойш дотоодын худалдан авалтад **37.4 их наяд** төгрөг зарцуулсан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2025, III УЛИРАЛ)

325
ТЭРБУМ ТӨГРӨГ

2025 оны гуравдугаар улиралд Өмнөговь аймагт бүртгэлтэй 101 ханган нийлүүлэгчээс 325 тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээ авлаа. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт **5.8 их наяд** төгрөгийн бараа, үйлчилгээ авчээ.

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын
ажиллагаа



Хөрст дэлхий

Эх дэлхийгээ
эрхэмлэн хамгаална




Хүртэх өгөөж

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР


(2025, III УЛИРАЛ)



2013 оноос хойш 2025 оны гуравдугаар улирлын байдлаар ус ашигласны төлбөрт нийт **211 тэрбум төгрөг** төлсөн.



2025 оны гуравдугаар улиралд ус дахин ашиглалтын зорилт 80 хувь байсан бөгөөд зорилтоо давуулан биелүүлж, дунджаар 86.5 хувьд хүргэв.



“100 САЯ МОД ӨВЛҮҮЛЭН ҮЛДЭЭ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАРААХ АЖЛУУДЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ:

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Цагаан зур голын орчимд хариуцлагагүй уул уурхайн улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон нийт 600 га талбайд газрын нөхөн сэргээлт хийх ажил амжилттай үргэлжилж байна.

“Оюу толгой” компани мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор нэн шаардлагатай 15 нэр төрлийн 53 ширхэг тоног төхөөрөмжийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хүлээлгэн өглөө.

“Оюу толгой” компани навчит, шилмүүст болон жимсний модны суулгацыг ажилтнууддаа үнэ төлбөргүй тараах ажлыг хавар болон намрын улиралд тогтмол зохион байгуулдаг. 2025 онд бид давхардсан тоогоор нийт 2000 гаруй ажилтнуудад ойролцоогоор 37,000 ширхэг модны суулгац тараасан байна.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ


(НЭГ ТОНН ХҮДЭР БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ, ШОО МЕТР, САРААР)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа 2025 оны гуравдугаар улиралд нөхөн сэлбэлтээр 0.44 м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХАЯГДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

(ХУВЬ, САРААР)



2025 оны гуравдугаар улиралд нийт үүссэн хаягдлын дунджаар 79 хувь нь дахивар нөөц байна.

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын
ажиллагаа



Хөрст дэлхий




Хүртэх өгөөж

Тогтвортой
үнэ цэн бүтээнэ

- Гүний уурхайн Хоёрдугаар анхдагч бутлуур болон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн хүрээнд хийсэн Тавдугаар бөмбөлөгт тээрмийн барилгын ажил амжилттай дуусч, Улсын комисст хүлээлгэн өглөө. Эдгээр байгууламжууд нь уурхайн үйл ажиллагааны чухал хэсгүүд бөгөөд Хоёрдугаар анхдагч бутлуур нь гүний уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх сүүлийн гол дэд бүтэц юм.
- 9 дүгээр сард 41 багийн нийт 958 хүн ажилласан баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөт зогсолт буюу их засварын ажил хийгдсэн ч гуравдугаар улиралд зэсийн үйлдвэрлэлийн дээд амжилт тогтоолоо. (Энэхүү засварыг 10 дугаар сард хийхээр төлөвлөж байсан ч үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд орсон өөрчлөлттэй холбоотой 9 дүгээр сард хийсэн юм.)
- Гүний уурхайн Панел 2 хойд хэсгийн анхны хүдэр буулгуурыг 8 дугаар сард буюу төлөвлөгөөт хугацаанаас 9 сарын өмнө амжилттай тэсэллээ.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(МЯН.ТОНН)



2025 онд зэсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт төлөвлөгөөний дагуу үргэлжилж байгаа бөгөөд өсөлт оны сүүлийн улиралд эрчимжсэн хэвээр байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ

(МЯН.УНЦ)



Алтны үйлдвэрлэл гуравдугаар улиралд мэдэгдэхүйц өссөн нь гүний болон ил уурхайн үйл ажиллагаа өндөр гүйцэтгэлтэй байгаатай холбоотой.

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia

